



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/226

Булган сум

**Хилийн цэргийн 0286 дугаар ангийн орон сууц
барих зардалд хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны VI/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хилийн цэргийн 0286 дугаар ангийн заставын алба хаагчдын орон сууц барих зардалд 50,000,000 (тавин сая) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх хөрөнгөд шаардагдах 50,000,000 (тавин сая) төгрөгийг 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийг данс бүртгэлд тусган, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Хилийн цэргийн 0286 дугаар ангийн захирагч (хурандаа Л.Цогтжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР